



АМАРПОС 2.0

ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

Дэлгүүрийн касс, бараа материал болон тайлангийн үндсэн заавар

MajorSoft LLC

2026 оны 08 сар

АМАРПОС 2.0

Гарын авлагын тухай

Энэхүү гарын авлага нь дэлгүүрт ашиглах АмарПОС 2.0 програмын үндсэн ажиллагааг тайлбарлана.

Тусламж: Даваа-Баасан 09:00-18:00, цайны цаг 12:30-13:30. Facebook Page-ээр мессеж илгээх боломж 24/7.

Утас	7000-3214
И-мэйл	info@majorsoft.mn
Вэб	www.majorsoft.mn
Facebook	facebook.com/AmarPOS3.0


Гарчиг

1. Програмд нэвтрэх	3
2. Үндсэн дэлгэц	4
3. Барааны бүртгэл	5
4. Барааны орлого	8
5. Борлуулалт ба төлбөр	10
6. Борлуулалтын буцаалт	12
7. Тайлан	13
8. Тохиргоо	17
9. Принтерийн тохиргоо	18
10. Тусламж авах	21

АМАРПОС 2.0

1. Програмд нэвтрэх

АмарПОС-ыг ажиллуулсны дараа хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруулж системд нэвтэрнэ.



Зураг 1. АмарПОС 2.0 нэвтрэх дэлгэц


1. Хэрэглэгчийн нэрээ сонгоно эсвэл оруулна.
2. Нууц үгээ оруулна.
3. Нэвтрэх товчийг дарна.

Анхаарах: Нууц үгээ бусдад дамжуулахгүй. Нэвтрэх боломжгүй бол Caps Lock асаалттай эсэхийг шалгаад, менежер эсвэл системийн админтай холбогдоно.

АМАРПОС 2.0

2. Үндсэн дэлгэц

Үндсэн дэлгэцийн дээд хэсэгт кассчинд зориулсан шууд үйлдлүүд, доод хэсэгт Систем, Бүртгэл, Гүйлгээ, Тайлан цэсүүд байрлана.



Зураг 2. АмарПОС 2.0 үндсэн дэлгэц

Цэсийн бүтэц

- Дээд цэс: кассчинд байнга хэрэгтэй борлуулалт, буцаалт болон шууд үйлдлүүд.
- Систем: програм, төхөөрөмж болон системийн ажиллагаатай холбоотой хэсэг.
- Бүртгэл: бараа болон холбогдох лавлах мэдээлэл.
- Гүйлгээ: орлого, борлуулалт, буцаалт зэрэг хөдөлгөөн.
- Тайлан: борлуулалт, үлдэгдэл, ашиг болон график мэдээлэл.

Зөвлөгөө: Цэс эсвэл товчлуурын тайлбар ойлгомжгүй үед хулганы заагчийг тухайн товч дээр түр байрлуулж тайлбарыг харна.

АМАРПОС 2.0

3. Барааны бүртгэл

Барааны жагсаалтаас бараа хайх, шинээр нэмэх, засах болон мэдээллийг хянах боломжтой.

Баркод	Барааны нэр	Үнэ	Бүлэг	Нийлүүлэгч	Тоо ширхэг	Өртөг	Дундаж өртөг	Нийт өртөг	Нийт дүн	Тайлбар	Бөөн тоо	Бөөн үнэ	Өөрчлөх огноо
03114615...	Ansung noodle so...	3,000	гурил будаа		-1.33	1,500		-2,000.25	-4,000.5		0	0	2025.09.11 1...
03800013...	Pringles cheese	5,000	бараа		8.67	5,000		43,350	43,350		0	0	2025.09.11 1...
03800084...	pringles original 4...	4,700	бараа		9.46	2,000		18,927.2	44,478.92		0	0	2025.09.11 1...
03800084...	Pribbles onion 40g	4,700	бараа		-0.66	0		0	-3,110.46		0	0	
1	other	100	бараа		18	200,000		3,600,000	1,800		0	0	
1002112	чихэр	100	бараа		-1	5,000		-5,000	-100		0	0	
1002113	Цагаан будаа 1кг	3,800	гурил будаа		-1	0		0	-3,800		0	0	
1002116	Шар будаа 1кг	3,800	гурил будаа		-1	0		0	-3,800		0	0	
103	агтат	3,500	бараа		-10.23	0		0	-35,809.9		0	0	
1040	өнөг	800	бараа		-3.38	0		0	-2,706.24		0	0	
1040	өндөг	800	бараа		-3.38	0		0	-2,706.24		0	0	
1050	рулет	5,300	бараа		0	0		0	0		0	0	
1060	рулет	4,500	Ус ундаа		4.47	0		0	20,093.85		0	0	
112	Лууван 1кг	2,500	бараа		0	0		0	0		0	0	
2	тор	200	бараа		-0.15	0		0	-30.72		0	0	
200	Будаа	3,800	бараа		0	0		0	0		0	0	
213	Цагаан будаа 1кг	3,800	гурил будаа		0	0		0	0		0	0	
214	Элсэн чихэр 1кг	5,000	гурил будаа		0	0		0	0		0	0	
217	хиам 1кг	15,400	мах махан бү...		0	0		0	0		0	0	
30142602...	ла	1,700	бараа		0	0		0	0		0	0	
333	хуушур	2,000	бараа		0	0		0	0		0	0	
40002812...	Schoko listen 250g	7,500	бараа		0	0		0	0		0	0	
40005124...	trolli after	6,800	бараа		0	0		0	0		0	0	
40005124...	trolli play mouse	6,800	бараа		0	0		0	0		0	0	
40005124...	trolli	6,800	бараа		0	0		0	0		0	0	
40005124...	trollin kuu 150g	5,800	бараа		0	0		0	0		0	0	
40016863...	HARIBO goldbären	6,000	бараа		0	0		0	0		0	0	
40016863...	haribo sweet sour...	6,000	бараа		0	0		0	0		0	0	
40016863...	haribo fruity bussl	6,000	бараа		0	0		0	0		0	0	
40016865...	MAOAM mix	9,500	бараа		0	0		0	0		0	0	
40016865...	haribo /halloween...	6,500	бараа		0	0		0	0		0	0	
40053403...	hik look	3,500	бараа		0	0		0	0		0	0	

Зураг 3. Барааны жагсаалт

- Баркод эсвэл барааны нэрээр шүүлт хийж хайна.
- Шинэ товчоор бараа нэмнэ.
- Сонгосон барааны мэдээллийг Засах товчоор шинэчилнэ.
- Жагсаалтын үлдэгдэл, үнэ болон бусад баганын мэдээллийг нягтална.

Анхаарах: Бодит үлдэгдэлд хөдөлгөөн орсон барааг устгахын өмнө холбогдох тайлан, гүйлгээг нягтална.

АМАРПОС 2.0

3.1 Шинээр бараа бүртгэх

Барааны үндсэн мэдээллийг бүрэн оруулснаар борлуулалт, үлдэгдэл болон тайлан зөв ажиллана.

Болих Хадгалах

Баркод Баркод ... +

Барааны нэр Барааны нэр

Үнэ 0

Бүлэг Бүлэг сонгох +

Хэмжих нэгж Ширхэг +

Нийлүүлэгч Нийлүүлэгч +

Нэгж Өртөг 0

Эхний үлдэгдэл 0

Ашгийн хувь % : 0 ☐ Цэсэнд харагдах эсэх

Б/Ү ангилал 2800000 ...

Бөөн тоо 0

Бөөн үнэ 0

Пос Салбар

Бусад Тэмдэглэл

Зураг

Gen3orig (Windows Virtual Camera) Web camera ажиллуулах

Зураг 4. Шинэ бараа бүртгэх хэсэг

1. Барааны жагсаалтаас Шинэ товчийг дарна.
2. Баркод болон барааны нэрийг оруулна.
3. Харьяалах тасаг, хэмжих нэгж болон шаардлагатай төрлийг сонгоно.
4. Өртөг, худалдах үнэ болон татварын тохиргоог нягтална.
5. Хадгалах товчийг дарна.

Анхаарах: Ижил баркодыг давхар бүртгэхгүй. Үнэ болон татварын сонголтыг хадгалахаас өмнө дахин шалгана.

АМАРПОС 2.0

3.2 Барааны мэдээлэл засах

Барааны нэр, үнэ, ангилал болон бусад мэдээллийг сонгосон мөрөөс засварлана.

Болх Хадгалах

Баркод Баркод ... +

Барааны нэр Барааны нэр

Үнэ 0

Бүлэг Бүлэг сонгох +

Хэмжих нэгж Ширхэг +

Нийлүүлэгч Нийлүүлэгч +

Нэгж Өртөг 0

Эхний үлдэгдэл 0

Ашгийн хувь % : 0 ☐ Цэсэнд харагдах эсэх

Нөөцийн мах

Б/У ангилал 2800000 ...

Бөөн тоо 0

Бөөн үнэ 0

Пос Салбар

Бусад Тэмдэглэл

Зураг

Gan3orig (Windows Virtual Camera) v

Web cameraг ажиллуулах

Зураг 5. Барааны мэдээлэл засах

1. Барааны жагсаалтаас засах бараагаа сонгоно.
2. Засах товчийг дарна эсвэл сонгосон мөрийг хоёр товшино.
3. Өөрчлөх мэдээллээ оруулж, үнэ болон татварын тохиргоог нягтална.
4. Хадгалах товчийг дарна.

Зөвлөгөө: Үнэ өөрчлөхөөс өмнө тухайн барааны идэвхтэй үнийн бодлого болон салбарын тохиргоог шалгаарай.

АМАРПОС 2.0

4. Барааны орлого

Нийлүүлэгчээс ирсэн барааг орлогоор бүртгэснээр барааны үлдэгдэл нэмэгдэнэ.

Зураг 6. Барааны орлогын жагсаалт

1. Гүйлгээ цэсээс барааны орлогын хэсгийг нээнэ.
2. Шинэ орлого үүсгэж огноо, нийлүүлэгч болон баримтын мэдээллийг оруулна.
3. Орлого авах бараануудыг баркод эсвэл нэрээр сонгоно.
4. Тоо ширхэг, өртөг болон нийт дүнг нягтална.
5. Гүйлгээг хадгалж баталгаажуулна.

Анхаарах: Буруу тоо эсвэл өртгөөр хадгалсан орлого нь үлдэгдэл болон ашгийн тайланд нөлөөлнө.

АМАРПОС 2.0

4.1 Орлогын дэлгэрэнгүй

Орлогын баримтын бараа тус бүрийн тоо, өртөг, үнэ болон нийлбэр дүнг дэлгэрэнгүйгээр хянаана.

Бараа Орлого

Дугаар: 4 Хөнгөлөлтийн %: 0%

Гүйлгээний утга: Гүйлгээний утга Нийлүүлэгч: Нийлүүлэгч

Огноо: 2026.08.20 Өнөө үүсгэлтэй жин: 0% НБАТ шалтгаан жин: 0%

Баримд сонгох: Лос Санбар Барааны үнэ өөрчлөх

Баркод	Барааны нэр	Тоо	Х.М дахь тоо	Өртөг	Нийт өртөг	Нэгж үнэ	Нийт үнэ	Ашигын хуви	НБАТ дүн	НБАТ-гүй нийт өртөг
038000138577	Pringles cheese	10	1	5,000	50,000	5,000	50,000	0%	0	50,000
1002113	Цагаан будаа 1кг	20	1	1,500	30,000	3,800	76,000	153.33%	0	30,000

80,000 126,000 0 80,000

Систем Бүртгэл Гүйлгээ Тайлан Үнэ хэвлэх 2.6.0.4-4225 Админ Microsoft Print to PDF 2026.08.20


Зураг 7. Барааны орлогын дэлгэрэнгүй

- Баримтын огноо, дугаар болон нийлүүлэгчийн мэдээллийг шалгана.
- Бараа бүрийн тоо, өртөг болон худалдах үнийг тулгана.
- Нийт тоо болон нийт дүн анхан баримттай таарч байгаа эсэхийг шалгана.
- Хэвлэх эсвэл экспортлох боломж байвал шаардлагатай хэлбэрээр хадгална.

АМАРПОС 2.0

5. Борлуулалт хийх

Кассын дэлгэцээр барааг сагсанд нэмээд төлбөрийн хэлбэрийг сонгон борлуулалтыг хаана.



Зураг 8. Борлуулалтын кассын дэлгэц


1. Баркод уншуулах эсвэл барааг жагсаалтаас сонгож сагсанд нэмнэ.
2. Барааны нэр, тоо, үнэ болон нийт дүнг нягтална.
3. Шаардлагатай бол тоо ширхэг болон зөвшөөрөгдсөн хөнгөлөлтийг өөрчилнө.
4. Төлбөр товчийг дарж төлбөрийн цонх руу шилжинэ.

Зөвлөгөө: Төлбөр авахаас өмнө сагсан дахь бараа болон нийт дүнг үйлчлүүлэгчтэй тулгана.

АМАРПОС 2.0

5.1 Төлбөр хүлээн авах

Төлбөрийн цонхонд төлөх дүн, авсан мөнгө болон хариултыг нягталж борлуулалтыг дуусгана.



Зураг 9. Төлбөрийн цонх

1. Төлбөрийн хэлбэрийг сонгоно.
2. Авсан мөнгө эсвэл төлөгдсөн дүнг оруулна.
3. Төлсөн дүн, хариулт болон үлдэгдлийг нягтална.
4. Төлбөрийг баталгаажуулж баримтыг хэвлэнэ.

Анхаарах: Төлбөр баталгаажсаны дараа цонхыг дахин дарахгүй. Давхар борлуулалт үүссэн эсэхийг борлуулалтын жагсаалтаас шалгаж болно.

АМАРПОС 2.0

6. Борлуулалтын буцаалт

Өмнө борлуулсан барааг баримтаар нь сонгон буцаах үед барааны үлдэгдэл болон төлбөрийн мэдээлэлд өөрчлөлт орно.

Буцаалт

№ :

Ажлын огноо : 2026.08.20

Буцаалтын код : ... ДДТД :

Бэлэн бусын дүн :

Дугаар	Цаг	Хэрэглэгч	Нийт тоо	Нийт дүн
565295	15:58:39	Админ	1	100
565296	17:18:55	Админ	2	4,100

U-Point код :

Баркод :

Хайлт

Сэргээх

Ажлын огноо 2026.08.20 Администратор

Зураг 10. Борлуулалтын буцаалтын дэлгэц


1. Буцаалтын цонхыг нээж борлуулалтын баримтыг хайна.
2. Буцаах бараа болон тоо ширхэгийг сонгоно.
3. Буцаалтын дүнг шалгана.
4. Буцаалтыг баталгаажуулж шаардлагатай баримтыг хэвлэнэ.

Анхаарах: Буцаалтын эрхгүй хэрэглэгч буцаалт хийх боломжгүй. Буруу баримтад буцаалт хийхээс сэргийлж огноо, дүн, барааг заавал тулгана.

АМАРПОС 2.0

7. Тайлан

Тайлан цэсээс борлуулалт, үлдэгдэл, ашиг болон гүйлгээний мэдээллийг сонгосон хугацаагаар харна.



Зураг 11. Тайлангийн цэс

- Өдрийн тайлан: тухайн хугацааны борлуулалт, буцаалт, төлбөр болон кассын мөнгөний нэгтгэл.
- Товчоо тайлан: барааны эхний үлдэгдлээс одоогийн үлдэгдэл хүртэлх хөдөлгөөн.
- Борлуулалтын тайлан: баримт, бараа, өдөр болон хэрэглэгчээр шинжлэх боломж.
- Ашгийн тайлан: борлуулалт, өртөг болон бохир ашгийн нэгтгэл.
- График тайлан: борлуулалтын чиг хандлага, бараа болон ангиллын харьцуулалт.

Зөвлөгөө: Тайлан гаргахын өмнө эхлэх, дуусах огноо болон сонгосон шүүлтийг шалгана.

АМАРПОС 2.0

7.1 Өдрийн болон товчоо тайлан

Өдрийн тайлан нь кассын орлого, төлбөр, буцаалт болон тушаалтын дүнг нэгтгэнэ. Товчоо тайлан нь барааны хөдөлгөөнийг үлдэгдэлтэй нь хянана.

Гүйлгээний төрөл	Нийлбэр дүн
НӨАТ	382
НХАТ	0
Борлуулалт	4,200
Буцаалт	0
Картаар	0
Авлага	0
Дансаар	0
SocialPay	0
Голомт IPPOS	0
Хаан E-Ros	0
Төрийн банк	0
ХХБанк	0
HiPay	0
QPay	0
EasyPay	0
БЭЛНЭЭР ДҮН	4,200
Купон орлого	0
Купон борлуулалт	0
Худалдан авалт Орлого	0
Акт ба зарлага	0
Эхний үлдэгдэл	0
Бэлэн мөнгө орлого	0
Бэлэн мөнгө зарлага	0
Эцсийн үлдэгдэл	0
НИЙТ ТУШААССАН	0
ЗӨРҮҮ	-4,200
Гүйцэтгэсэн	0

Зураг 12. Тайлангийн нэгтгэсэн харагдац

- Эхлэх болон дуусах огноог зөв сонгоно.
- Борлуулалт, буцаалт, НӨАТ, төлбөр болон кассын мөнгөний дүнг харьцуулна.
- Зөрүү гарсан бол борлуулалт, буцаалт болон бэлэн мөнгөний гүйлгээг тулгана.
- Шаардлагатай бол тайланг хэвлэх эсвэл файл болгон экспортлоно.

АМАРПОС 2.0

7.2 Бараа болон гүйлгээний тайлан

Бараа тус бүрийн борлуулалт, буцаалт, орлого, зарлага болон үлдэгдлийн хөдөлгөөнийг дэлгэрэнгүй харна.

Мэжир Дэлгүүр

Борлуулалт (F1)Буцаалт (F2)Балан нөгөө (F3)

Өдрийн мэдээБалан мөнгөний дэлгэрэнгүйТовчоо тайлан

Хайлт ...

Бүх барааЭхний үлдэгдэлтэй

ӨртөгөөрҮнийн дүнгээрТооцоогоор

Баркод	Барааны нэр	Үнэ	Эхний...	Орлого	Зарлага	Борлуулалт	Буцаалт	Эцсийн...
038000138577	Pingles cheese	5,000	0	11	0	13.33	0	8.67
03800045529	Pingles onion 40g	4,700	0	0	0	0.662	0	-0.662
103	апельс	3,500	0	0	10	97.231	0	-10.231
1040	өмдөг	800	0	0	0	3.383	0	-3.383
214	Элсэн чөдөр 3кг	5,000	0	0	0	0	0	0
3014260287047	ла	1,700	0	0	0	7	0	0
4001686301265	NARISO goldbaten	6,000	0	0	0	0	0	0
4001686375518	harbo fruity buss	6,000	0	0	0	0	0	0
4014402400007	Tuffkee	8,500	0	0	0	0	0	0
4311596419628	гөрлөн давс	3,700	0	0	0	0	0	0
4600697101613	Гликемическө	2,500	0	0	0	0	0	0
4600851011161	тос 1л	8,500	0	0	0	0	0	0
4605504522728	каравак шофит ...	5,500	0	0	0	0	0	0
4606273003241	алекка	3,500	0	0	0	0	0	0
4607022923999	котлетт	3,400	0	0	0	7	0	0
4607046120141	Русский салат S...	4,000	0	0	0	0	0	0
4607084352542	CHOCO PIE нэм...	9,800	0	0	0	0	0	0
4607084353631	Choco pie гүзлж...	9,800	0	0	0	0	0	0
46078483	drol	1,400	0	0	0	0	0	0
4610003950033	кука / water	3,600	0	0	0	0	0	0
46214614	mentos	1,700	0	0	0	10	0	0
46214645	mentos	1,700	0	0	0	0	0	0
4650062772924	Нэм чөдөр жонг...	3,000	0	0	0	0	0	0
4650075425282	ноя том	8,400	0	0	0	0	0	0
4690388106645	lays 225г	10,500	0	0	0	0	0	0
4690388116163	lays	3,500	0	0	0	42	0	0
4800888169693	sursik	600	0	0	0	0	0	0
4820003830017	Обыное	2,000	0	0	0	0	0	0
48746489	mentus	3,200	0	0	0	0	0	0
48746786	mentus	3,550	0	0	0	0	0	0
4903111996377	Sofy шөнө	8,600	0	0	0	0	0	0
5000174349672	safeguard сапан	3,300	0	0	0	46	0	0
50173747	Обыт	1,400	0	0	0	28	0	0
5900516311421	bella aroma	4,600	0	0	0	2	0	0
5902978020033	KDcaez	1,800	0	0	0	2	0	0
		5	45	11	22,747.55	0	16.45	

1 / 515

СистемБүртгэлГүйцэтгэлТайланҮнэ хязлал

2.6.0.4-4225АдминMicrosoft Print to PDF2026.08.20

Зураг 13. Бараа тус бүрийн тайлан

Өдрийн мэдээ

Балан мөнгөний дэлгэрэнгүй

Товчоо тайлан

Борлуулалт өдрөөр

Дэлгэрэнгүй

Хайлт

Огноо : 1995.08.20 - -аас 2026.08.20



Хайлт

Амьсгал өгсөн	Нийт тус	Нийт дүн	Нийт H&AT	Нийт H&AT
2024.02.02	665.055	2,349,369	166,266.433	5,034.234
2023.10.23	569.275	1,879,611	118,233.948	1,776.577
2026.08.20	3	4,200	381.818	
2023.12.27	422.015	1,437,533	97,735.852	2,430.63
2023.07.27	507.715	1,698,600	108,129.09	1,800
2024.03.15	600.835	2,007,869	180,984.519	8,539.286
2024.03.21	733.035	2,286,866	207,031	9,525
2024.02.15	299.87	979,575	88,477.435	6,323.214
2023.11.10	552.945	1,758,852.5	118,276.844	2,907.207
2024.04.16	626.915	1,845,555.5	167,427.771	3,850
2024.05.26	751.985	2,128,765	193,041.623	5,307.143
2024.01.22	540.325	1,656,431.5	108,146.259	2,048.649
2023.12.15	770.33	2,794,486	191,607.598	5,769.369
2023.12.07	591.285	1,649,862	103,449.072	2,415.315
2023.10.18	459.735	1,393,578	92,966.662	2,211.712
2023.07.08	597.925	2,167,457.5	143,957.725	3,213.514
2024.01.30	437.55	1,516,400	102,961.191	2,291.892
2024.05.13	709.295	1,840,804.5	166,995.376	3,855.357
2023.11.21	565.245	1,879,039.5	124,597.205	4,543.243
2023.11.07	785.175	2,571,055.5	172,152.156	4,383.784
2023.11.27	570.63	1,885,542	123,961.438	4,789.189
2023.08.17	641.66	1,599,278	109,402.56	2,946.847
2023.10.26	675.805	1,885,309	123,498.934	2,211.712
2023.09.23	523.73	1,609,806	115,115.222	3,167.508
2024.05.04	566.345	1,386,485	125,823.149	2,430.357
2023.11.12	683.98	2,227,152	132,811.15	2,142.342
2023.06.23	685.905	2,172,866.5	137,249.289	2,815.315
2023.06.02	585.345	1,771,862	130,891.807	3,026.126
2024.01.06	532.37	1,630,280	107,074.058	3,260.361
2024.04.29	798.38	2,247,399.5	203,578.04	8,041.071
2024.05.01	729.565	2,220,015.5	201,081.116	8,123.214
2023.12.26	722.96	2,153,102.5	141,002.782	3,591.892
193182.7		613,821,773.3	43,932,913.97	1,346,782.54

1 / 329

Систем

Бүртгэл

Гүйцэтгэл

Тайлан

Үнэ хязлал

Бүтэц


Зураг 14. Огноо болон дүнгээр харуулсан тайлан

Анхаарах: Тайлангийн дүнг тайлбарлахдаа сонгосон хугацаа, салбар, хэрэглэгч болон барааны шүүлт идэвхтэй эсэхийг шалгана.

АМАРПОС 2.0

7.3 Борлуулалтын график

График тайлан нь борлуулалтын өөрчлөлт болон бараа, ангиллын харьцуулалтыг хурдан харахад ашиглагдана.



Зураг 15. Борлуулалтын график тайлан

- Хугацааны борлуулалтын чиг хандлагыг шугаман графикаар харна.
- Их борлуулалттай бараа болон ангиллыг харьцуулна.
- Огнооны шүүлт өөрчлөгдөх бүрд графикийн утгыг дахин ачаалж шалгана.

Зөвлөгөө: График дээрх ер бусын өсөлт, бууралтыг тухайн өдрийн дэлгэрэнгүй борлуулалтын тайлантай тулган шалгаарай.

АМАРПОС 2.0

8. Тохиргоо

Тохиргооны хэсэгт бизнесийн мэдээлэл, төхөөрөмж, принтер болон програмын ажиллах горимтой холбоотой сонголтууд байрлана.

Зураг 16. Тохиргооны дээд хэсэг

Зураг 17. Тохиргооны доод хэсэг

- Бизнесийн нэр болон баримтад хэвлэгдэх мэдээллийг зөв оруулна.
- Принтер, порт болон баримтын сонголтыг төхөөрөмжтэй тулгаж тохируулна.
- Татвар болон төлбөрийн сонголтыг дур мэдэн өөрчлөхгүй.
- Өөрчлөлт хийсний дараа Хадгалах товчийг дарж програмыг шаардлагатай бол дахин нээнэ.

Анхаарах: Тохиргооны буруу өөрчлөлт нь баримт хэвлэх болон тайлангийн дүнд нөлөөлж болно. Эргэлзээтэй бол 7000-3214 дугаараас зөвлөгөө авна.


АМАРПОС 2.0

9. Принтерийн тохиргоо

Баримт хэвлэхгүй үед эхлээд физик холболт, цаас болон АмарПОС доторх принтерийн сонголтыг дарааллаар шалгана.

Эхний шалгалт

1. Принтерийн цахилгаан ассан, алдааны гэрэл анивчаагүй эсэхийг шалгана.
2. USB кабель компьютер болон принтерт бүрэн орсон эсэхийг шалгана.
3. Принтерийн цаас байгаа, зөв харсан байрлалтай эсэхийг шалгана.
4. Өмнө ашиглаж байсан USB оролтод залгасан эсэхийг шалгана.
5. АмарПОС → Тохиргоо хэсэгт зөв принтер сонгогдсон эсэхийг шалгана.



Зураг 18. АмарПОС доторх төхөөрөмж болон принтерийн тохиргооны хэсэг

Зөвлөгөө: Цаасыг бага зэрэг илүү гаргаж хаалтыг бүрэн түгжинэ. Дулааны цаас буруу харсан бол принтер ажилласан ч хоосон цаас гарч болно.

АМАРПОС 2.0


9.1 Windows-д принтер танигдсан эсэх

Физик холболт хэвийн боловч хэвлэхгүй бол Windows төхөөрөмжийг зөв таньсан эсэхийг шалгана.


1. Windows Start цэсэнд Control Panel гэж бичээд нээнэ.
2. Hardware and Sound → Devices and Printers хэсэг рүү орно.
3. Принтер жагсаалтад идэвхтэй харагдаж байгаа эсэхийг шалгана.
4. Бүдэг саарал эсвэл Offline байвал кабель, USB оролт болон принтерийн цахилгааныг дахин шалгана.




Гарж ирсэн цонхны Hardware and Sound цэсний [View device and printers] дээр дарна



Зураг 19. Control Panel болон Devices and Printers рүү орох



Хэвлэгч принтер кассын төхөөрөмжтэй холбогдоогүй бол **Unspecified** хэсэгт хосон байх ба хэвлэгч Принтер будаг саарал өнгөтэй болж харагдана. Энэ үед принтер хэвлэгчийн холболтын сайтар шалгаж, **Unspecified** хэсэгт төхөөрөмж орж иртэл болон идэвхгүй будаг саарал болсон хэвлэгчээ тод болтол USB оролт болон принтер дээр гэрэл асах эзэргийг сайтар шалгана.



Зураг 20. Windows төхөөрөмж болон принтерийн жагсаалт


АМАРПОС 2.0

9.2 Offline төлөв болон USB порт засах


Windows принтерийг таньсан боловч хэвлэхгүй үед offline төлөв болон портын сонголтыг шалгана.

1. Принтер дээр хулганы баруун товч дарж See what's printing цонхыг нээнэ.
2. Printer цэсний Use Printer Offline сонголт идэвхтэй байвал чагтыг авна.
3. Шаардлагатай бол Set as default printer сонголтыг идэвхжүүлнэ.
4. Printer properties → Ports хэсгээс USB001, USB002, USB003 зэрэг портыг шалгана.
5. Портыг өөрчилсний дараа Apply/OK дарж туршилтын баримт хэвлэнэ.


Принтер үүдэг саарал өнгөтэй байвал тухайн принтер дээрээ Mouse 2 буюу хулганы баруун товчлуурыг дараад



Printer цэсэн дээр дараад Use offline printer-ийн урд чагталсан чагтыг дээр нь дарж авна.



Printer цэсэн дээр дараад Properties дээр дарж Port гэсэн хэсгээр үүрж USB001 USB002 USB003 (USB порт 003-аас дээш хэд ч гэж гарж ирж болно) гэх мэт портуудын аль нэгийг шалган чагталж OK товчыг дарснаар принтер хэвлэгчийн зөрсөн порт засагдан хэвлэхэд бэлэн болно. (001 биш бол 002 гэх мэт зарчмаар аль портонд байгааг нэг нэгээр идэвхжүүлж үзэхэд аль байгаа портондоо таарсан тохиолдолд хэвлэх команд өгхөд шууд хэвлэгдэнэ)



Зураг 21. Offline төлөв, үндсэн принтер болон USB портын сонголт

Анхаарах: Аль порт зөв болох нь USB оролтоос хамаарна. Портыг нэг нэгээр туршихдаа өөр принтерийн тохиргоог өөрчлөхгүй.

АМАРПОС 2.0

10. Тусламж авах

Асуудлыг хурдан шийдвэрлэхийн тулд операторт дараах мэдээллийг бэлдэж өгнө.

- АмарПОС-ын дэлгэц дээр гарсан алдааны бүтэн screenshot.
- Ямар цэс, ямар үйлдэл хийх үед алдаа гарсан тухай товч тайлбар.
- Алдаа гарсан огноо, цаг болон нэвтэрсэн хэрэглэгчийн нэр.
- Принтерийн асуудал бол төхөөрөмжийн загвар, гэрлийн төлөв болон USB холболтын мэдээлэл.

Ажлын цаг: Даваа-Баасан 09:00-18:00. Цайны цаг 12:30-13:30. Facebook Page-ээр мессеж илгээх боломж 24/7.

Утас	7000-3214
И-мэйл	info@majorsoft.mn
Вэб	www.majorsoft.mn
Facebook	facebook.com/AmarPOS3.0

АМАРПОС 2.0-Г СОНГОСОН ТАНД БАЯРЛАЛАА

Таны дэлгүүрийн өдөр тутмын ажиллагааг илүү хялбар, хяналттай болгоно.